



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
ЗӨВЛӨМЖ

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 05

Номгон

Г Аймгийн Засаг даргын Тамгын газрын 7
хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийсэн тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд тайлангийн дундаж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 75 хувь, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 82.28 хувь, Аймгийн хөгжлийн төлөвлөгөө 53.2 хувь, дэд хөтөлбөр 74.6 хувь, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр 84.81 хувь, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тогтоол, шийдвэр 75.73 хувь, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэр 90.31 хувь, зөвлөмж 63.88 хувь, Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээ (сайдтай байгуулсан гэрээ) 81.47 хувь, хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө (тайлан) 94.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Дээрх үнэлгээнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт зөвлөж байна.

1.Хэлтсийн 2024 оны эхний хагас жилийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн 119, “Үр дүнгүй” дүгнэгдсэн 116 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлангийн загварын дагуу хүрсэн түвшин, зарцуулсан төсвийн тоон үзүүлэлтийг тайлбар (хэрэгжилт буюу гүйцэтгэлийн үр дүн)-ын хамт тайлагнах;

3.Хэлтэс бүр салбарын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн санг 2024 он хүртэл 5 жилийн тоон үзүүлэлтээр бүрдүүлэх;

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх, байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах, ил тод тод байдлын шалгуур үзүүлэлтийг тайлагнах хялбаршуулсан гарын авлагыг боловсруулан агентлаг, сумдад түгээх;

642341090

6.Зөвлөмжийг хэрэгжүүлэх нарийвчилсан (эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээг хэн, хэзээ, хэрхэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох г.м) төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, төлөвлөгөө, биелэлтийг зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд хавсарган ирүүлэх;

7.Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн тайланг “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журам”-ын дагуу харьяа агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагаас хагас, бүтэн жилээр авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж хэвших;

8.Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах;

9.Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээр хангалтгүй үнэлгээ авсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Залуучуудын хөгжлийн төв үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөгөө гарган, 2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын үр дүнг нэмэгдүүлж ажиллах;

10.Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар ирүүлэх;

ДАРГА  Л.МАНДАЛ

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЭЛТСҮҮДИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН**

2024 оны 07 дугаар сарын 29

Номгон

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, аргачлал, хамрах хүрээ:

Нутгийн захиргааны байгууллагуудын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд, аймгийн Засаг даргын харьяа агентлагуудын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баримтлав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт;
- Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт;
- Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;
- Зөвлөмжийн хэрэгжилт;

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө буюу Засгийн газрын гишүүнтэй аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үүргийн биелэлт;
- Хэлтсийн гүйцэтгэлийн тайлан;

Тайлангуудаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн

хэрэгжилт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт, Засгийн газрын гишүүнтэй аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт зэрэг 8 тайланг Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар хүлээн авч үнэлсэн.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг тайлан тус бүрээр танилцуулъя.

2.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын Тамгын газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 18 арга хэмжээг хяналтад авч, Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Цэргийн штаб 100 хувь хэрэгжүүлж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс тайлагнаагүй.

Хүснэгт 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үнэлгээний дүн:

Хэлтсийн нэр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Хугацаа болоогүй*	Дундаж үнэлгээ (%)
		100%	70%-90	50%	0%		
1	2	3	4	5	6	7	8
Нийгмийн бодлогын хэлтэс	1	1	-	-	-	-	100%
Санхүү, төрийн сангийн хэлтэс	1	1	-	-	-	-	100%
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	14	-	-	-	-	-	0%
Цэргийн штаб	3	3	-	-	-	-	100%

2.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 хэлтэс Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 163 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсийн нэр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж үнэлгээ (%)
1	2	3	4	5	6	7
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	17	8	8	1	-	85.29%
Хууль, эрх зүйн хэлтэс	11	5	5	1	-	80%
Нийгмийн бодлогын хэлтэс	80	15	52	11	2	75.62%
Санхүү, төрийн сангийн хэлтэс	12	7	4	-	1	81.67%
Хөгжлийн төлөвлөлт, бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс	43	29	12	2	-	88.84%

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд эрчимжүүлэх шаардлагатай 15, үр дүнгүй 2 арга хэмжээ байна. Үүнд:

- 2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ зорилтын 6. Элэгний В вирустай эхчүүдээс төрсөн нярай бүрт Гепабиг эмчилгээг нэвтрүүлэх;

- 2.1.4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ зорилтын 1. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, 2. Нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх, скрининг болон сонсголын гажиг илрүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх;

- 2.1.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана зорилтын 1. Иргэдийн хүлээгдэл чирэгдэлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх;

- 2.1.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ зорилтын 2. Иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, ёс зүйгээрээ бусдыгаа манлайлсан ажилтнуудыг урамшуулах, алдаршуулах;

- 2.1.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ зорилтын 4. Эрчимт эмчилгээ гемодиализын өргөтгөлийн барилга шинээр барих;

- 2.6.3. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ зорилтын 1. “Соёлтой Баянхонгорчууд” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- 2.7.1. “Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ” зорилтын 3. Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах;
- 2.8.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ зорилтын 2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх;
- 2.8.5. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана зорилтын 1. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, 2. Хөдөлмөр зусланг ажиллуулах;
- 3.1.3. Хуримтлалтай хонгорчууд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ зорилтын 2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- 3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана зорилтын 1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах;
- 4.3.4. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ зорилтын 1. Виртуал аялал хийх боломжтой “VR-Bayankhongor” төвийг байгуулж, контентийг нэмэгдүүлэх;
- 4.4.1. “Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна” Зорилтын 7. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх;
- 5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана зорилтын 1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

2.3. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ:

Хэлтсүүд аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 316 үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүн тайлагнасныг хянан үзэхэд 26.6 хувь “Үр дүнтэй”, 13.6 хувь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 26.3 хувь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 33.5 хувь “Үр дүнгүй” үнэлэгдэж, дундаж хэрэгжилт 53.2 хувьтай байна.

Хүснэгт 3.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсийн нэр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Дундаж үнэлгээ (%)
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1	2	3	4	5	6	7	
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	22	6	2	6	8	48.89%	
Хууль, эрх зүйн хэлтэс	17	3	5	9	-	63.33%	
Нийгмийн бодлогын хэлтэс	130	38	19	27	46	49.92%	
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	3	1	-	1	1	43.33%	
Санхүү, төрийн сангийн хэлтэс	5	2	1	1	1	64%	
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	132	31	15	38	48	42.87%	
Цэргийн штаб	7	3	1	1	2	60.0%	

2.4.Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд аймгийн 13 дэд хөтөлбөрийн 116 арга хэмжээг хэрэгжүүлэн, 74.63 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Хүснэгт 4.Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсийн нэр	Хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Дундаж үнэлгээ (%)
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1	2	3	4	5	6	7	8	
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	1	2	-	1	1	-	60%	
Хууль, эрх зүйн хэлтэс	4	18	2	12	3	1	72.73%	
Нийгмийн бодлогын хэлтэс	3	3	-	3		-	76.67%	
Санхүү, төрийн сангийн хэлтэс	1	2	1	1		-	95%	
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	4	91	25	42	17	7	68.76%	

Эрчимжүүлэх шаардлагатай дэд хөтөлбөрийн арга хэмжээ:

Эдийн засгийг сэргээн хөгжүүлж, тогтвортой хөгжлийг бий болгох “Баялаг бүтээгч-Баянхонгор” хөтөлбөрийн 1 арга хэмжээ:

- 2.1. Хүн ам төвлөрсөн, төв суурингийн ойролцоох бүс нутагт хагас эрчимжсэн МАА, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлж МАА, газар тариалангийн салбарт учирдаг байгалийн эрсдлийг бууруулан ашиг шим, бүтээмж, үр өгөөжийг нь дээшлүүлнэ.

Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрийн 6 арга хэмжээ:

- 1.1. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн эрх зүйн дараах баримт бичгүүдийг боловсруулан батлуулж мөрдөж ажиллах. Үүнд:
 - 1.1.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх,
 - 1.1.2.Энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах,
 - 1.1.3. Энэ хуулийн 40.4-т заасан урамшуулал олгох журмыг батлах;

- 1.3. Хог хаягдлын тухай хууль, төрөөс баримтлах бодлого, аймгийн дэд хөтөлбөр болон мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, мэдээллийн тогтолцоог аймаг, сумын ИТХ-д бий болгох;

- 2.4. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор дахивар, түүхий эд цуглуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах санал санаачилга төслүүдийг дэмжиж, энэ чиглэлээр жижиг үйлдвэрлэлийг бүсчилсэн байдлаар бий болгож хөгжүүлэх;

- 2.5. Органик хог хаягдал, тэр дундаа хүнсний, биомассын хог хаягдал, малын өтөг бууцыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бүрдүүлж, дахин боловсруулах, бордоо болгох, түлш, эрчим хүч гаргах технологи бүхий үйлдвэрийг байгуулах ТЭЗҮ боловсруулах;

- 3.2. Аймгийн төр, хувийн хэвшлийн байгууллагууд байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001 стандартыг нэвтрүүлэх ажлыг дэмжиж, хөнгөлөлттэй зээл олгох, гэрчилгээ авч баталгаажсан байгууллагыг сурталчлах ажлыг зохион байгуулах;

- 4.5. Аймгийн хэмжээнд хоггүй шилдэг сум, баг болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах компанит ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах;

"Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр - III" аймгийн дэд хөтөлбөрийн 10 арга хэмжээ:

- 1.2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг үнэлэх ажлыг зохион байгуулж загвар хоршоог хөгжүүлэх;

- 2.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийн эх үүсвэрийг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

- 3.1. Хоршооны бүтээгдэхүүн борлуулалтын төв, хөдөө аж ахуйн болон жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийн дундын цэгийг орон нутагт байгуулж, хоршоодын захиалгын дагуу нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

- 3.3. Загвар хоршоог байгуулж, хөрөнгө санхүүгээр дэмжих;

- 3.6. Үндэсний үйлдвэрт хоршоо бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх;

- 3.7. Хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх;

- 3.9. Хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, туршлага судлах зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах;

- 4.4. Хоршооллын салбарын залуу үеийг дэмжсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх;

- 4.5. Хоршооны гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах;

- 4.7. Хоршоог дэмжигч шилдэг төрийн түшээг сум, аймгийн түвшинд тодруулан өргөмжилж байх;

Ухаалаг Баянхонгор хөтөлбөрийн 1 арга хэмжээ:

- 4.1.4. Төрийн байгууллагуудад цахим хяналт, мэдээллийн системийг хөгжүүлж аймгийн удирдлагуудыг өдөр тутмын нэн шаардлагатай мэдээллээр хангана.

Зөв амьдрал дэд хөтөлбөрийн 2 арга хэмжээ:

- 2.1.2. “Жаргалтай амьдрал төв”-ийн эмчилгээнд хамрагдаж архинд донтох эмгэгээсээ салсан иргэдийн сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор 12 дугаар сард “Өөрийгөө ялсан хүн” арга хэмжээг зохион байгуулж, улсын хэмжээнд сурталчлах;

- 2.1.3. Архинд донтох өвчтэй хvн болон түүний гэр бүлийнхэнд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, энэ чиглэлээр гэр бүл, төрөл садан, хамт олны нөлөөлөл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;

“Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх” аймгийн хөтөлбөрийн 1 арга хэмжээ:

- 1.1. Шинээр ажилд томилогдон ажиллаж байгаа, удирдах болон гүйцэтгэх албан хаагчдад шаардлагатай төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн мэдээллээр хангах, мэдлэг чадвар эзэмшүүлэх, сургалтын тогтолцоо, орчинг бүрдүүлэх;

Цахим архив-Баянхонгор хөтөлбөрийн 1 арга хэмжээ:

- 1.1. Төрийн архивын цахим сангийн ажилтнууд сумдын мал тооллогын 1990-2018 онуудын баримтын бүртгэл болон өгөгдөлийг програмд шивж, баримтыг скайнердан ашиглалтын хувь үүсгэн, холболт хийх, хянуулж хүлээлцэх, бааз хуулуулах;

"Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт - 2028" дунд хугацааны бодлогын баримт бичиг 7 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

- 4.1. Экспортын чиглэлтэй, байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийг "Ажилсаг төв-Үйлдвэр технологийн парк"-ийн Бизнес инкубаторын төвөөр дамжуулан бойжуулах, шинэ дэвшилтэт болон өндөр технологи нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах

- 4.2. Баянхонгор аймгийн хүний болон түүхий эдийн нөөц, судалгаанд үндэслэн "Аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого"-ыг боловсруулж хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.

- 5.4. Дотоодын аяллыг хөгжүүлэх зорилгоор Өргөөтийн рашаан, Өхэгийн амралт, Жаргалант сумын Биндэръяа Хөх нөөр, Гурванбулагийн Хөх нуур, Бөөнцагаан нуур, Орог нуур, Эрхэт, Тамчийн хавцал, Өвгөнжаргалант, Номгон хайрхан зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад шаардлагатай тохижилт, үйлчилгээг хийж байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгож зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.

- 6.3. Өмноговь аймгийн Шивээхүрэнгийн боомт-Баянхонгор, Баянхонгор-Завхан аймгийн Улиастай чиглэлийн босоо тэнхлэгийн авто зам, Баянхонгор-Архангай аймгийн Цэцэрлэг хоттой холбогдсон бүс нутгийн хатуу хучилттай авто зам барьж байгуулна. Баянхонгор-Шаргалжуут рашаан чиглэлийн улсын чанартай авто замыг хатуу хучилттай болгох;

- 6.4. Ногоон барилгын стандартыг хэрэгжүүлж, шинээр баригдаж байгаа болон ашиглалтын шаардлага хангасан хуучин барилгуудад дулаалгын стандартыг нэвтрүүлэн барилгын дулааны алдагдлыг бууруулна.

- 7.3. Аймгийн төр захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ худалдан авахад зарцуулна.

- 7.4. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж, гадаад дотоодын "Ногоон хотууд"-ын туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

2.5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Хэлтсүүд Монгол Улсын хууль, Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар үүрэгжүүлэн өгсөн нийт 158 шийдвэрийн 278 заалтын хэрэгжилтийг хяналтад авч, 84.81 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсийн нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)							Дундаж үнэлгээ (%)
	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
1	2	3	4	5	6	7	8	9
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	27	74	65	7	1	-	1	96.16%
Хууль, эрх зүйн хэлтэс	14	20	10	9	-	-	1	85.79%
Нийгмийн бодлогын хэлтэс	29	58	7	45	4	2	-	68.45%
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	5	5	4	-	-	1	-	80%
Санхүү, төрийн сангийн хэлтэс	13	16	9	3	-	-	4	92.50%
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	68	103	54	38	-	2	9	85.74%
Цэргийн штаб	2	2	1	1	-	-	-	85%

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт хангалтгүй 5, хэрэгжээгүй 5 заалт байна. Үүнд:

- Журам батлах тухай Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолын 3.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн

мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)

- Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай Ерөнхийлөгчийн 2022 оны 159 дүгээр зарлигийн 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.

- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухааны спортын байнгын хорооны 2021 оны 05 дугаар тогтоолын 1.2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх; 1.3. нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан орон тоог бий болгож, цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх;

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийн ХХХХ.11.4. Монгол Улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглабарыг гадаадад сурталчлах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин нарт, цаглабарт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ болон Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.

- Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолын 2.2. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих;

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 06/05 дугаар зөвлөмжийн 1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх;

- Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлийн XIX.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийн хүрээнд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх, хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй 81 шийдвэрийг зохих журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээг тус тус 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав

- Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.

2.6.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 53 тогтоол, шийдвэрийн 57 заалтыг 75.73 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 6.Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсүүдийн нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)							Дундаж үнэлгээ (%)
	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
1	2	3	4	5	6	7	8	9
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	4	4	4	-	-	-	-	100.00%
Хууль, эрх зүйн хэлтэс	9	9	5	2	-	-	2	91.43%
Нийгмийн бодлогын хэлтэс	7	8	-	5	3	-	-	55.00%

1	2	3	4	5	6	7	8	9
Санхүү, төрийн сангийн хэлтэс	8	10	6	4	-	-	-	88.00%
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	23	24	6	10	1	2	5	70.00%
Цэргийн штаб	2	2	-	1	1	-	-	50.00%

Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хэрэгжилт хангалтгүй 5, хэрэгжээгүй 2 заалт байна. Үүнд:

- Боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023 оны 16/45 дугаар тогтоолын Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө төсвийг жил бүрийн аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай бэлтгэж ороцсон сургууль, багш сурагчдыг шалгаруулах болзолт журам"-ын хэрэгжилтийг хангалттай гэж үзсэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, элсэлтийн Ерөнхий шалгалтын шинэчилсэн журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханд даалгасугай.

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх /2023-2026 он/ арга хэмжээний төлөвлөгөө тухай 2023 оны 17/68 дугаар тогтоолын 1. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутаг, холбогдох салбарын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны хяналт шинжлэгээг тогтмол, үнэлгээг 2 жил тутам хийж, биелэлтийн мэдээг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

- Аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулж, ажиллах журмыг батлах тухай 2021 оны 142 дугаар тогтоолын 1. Аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих гаргасан бодлого, шийдвэр, зөвлөмжийг аймгийн бодлогод тусгаж хамтран ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай

- Нээлттэй Баянхонгор аймаг" хөтөлбөр батлах тухай 2023 оны 13/14 дүгээр тогтоолын 1. Аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай. 1. Хөтөлбөрийг

хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажилласугай. 2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудлыг орон нутгийн төсөвт тусгаж батлуулсугай. 3. Төлөвлөөний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг тухайн оны эцэст аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулсугай.

- Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг тогтоох тухай 2023 оны 16/48 дугаар тогтоолын 1. Иргэдэд газар өмчлүүлэх ажлын тайланг 2024 оны 12 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

2.7.Аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд Засаг даргын 98 захирамж, албан даалгаврын 224 заалтыг хэрэгжүүлж, тайлагнасныг хянан үзэж, 90.31 хувиар үнэллээ.

Хүснэгт 7.Аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсүүдийн нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)							Дундаж үнэлгээ (%)
	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
1	2	3	4	5	6	7	8	9
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	9	40	36	4	-	-	-	97%
Хууль, эрх зүйн хэлтэс	16	28	23	3	1	-	-	94.07%
Нийгмийн бодлогын хэлтэс	16	42	21	16	4	1	1	81.46%
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	2	17	11	4	-	-	2	92.00%
Санхүү, төрийн сангийн хэлтэс	9	20	16	2	-	-	2	96.67%
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	42	74	51	13	3	-	7	91.04%
Цэргийн штаб	3	9	8	1	-	-	-	92.70%
Залуучуудын хөгжлийн төв	1	4	1	3	-	-	-	77.50%

Аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хэрэгжилт хангалтгүй 8, хэрэгжээгүй 1 заалт байна. Үүнд:

- Дотоодын 832 дугаар тусгай салбарын харуулын цэг, харуулын байрыг засварлахад хөрөнгө зарцуулах тухай 2024 оны А/223 дугаар захирамжийн 1. Дотоодын цэргийн тусгай салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга дэд хурандаа (Б.Мөнхбаатар)-т, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайланг гаргаж ажиллахыг дотоодын цэргийн 832 дугаар тусгай салбарын захирагч, хошууч (Д.Гончигсүрэн)-д тус тус үүрэг болгоусгай.

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх /2023-2026/ арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хөрөнгө заруцлах тухай 2024 оны А/141 дүгээр захирамжийн 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т тус тус үүрэг болгосугай.

- Бодлогын баримт бичиг,хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, төрийн алба хаагчдын үүрэг хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх тухай 2024 оны 02 дугаар албан даалгаврын 5. 1.5.Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх; 28. 2.15.Инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаанд нэвтрүүлж, зохих заавар журмын дагуу оюуны өмчийн газар бүртгүүлж, патент авч баталгаажуулах; 34. 2.21.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний хүрсэн түшингээ бататгаж, 2-5 хувиар нэмэгдүүлж ажиллах;

- "Үнэт баялаг-Ус" нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах тухай 2024 оны А/305 дугаар захирамжийн 1. "Үнэт баялаг-Ус" нөлөөллийн арга хэмжээний хүрээнд усны нөөцийн хомсдол бохирдлоос хамгаалах, усны чанар, зүй зохистой хэрэглээг олон нийтэд сурталчлан таниулах олон талт арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, ажлын тайлан, холбогдох баримт бичгийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн архивын тасагт хүлээлгэн өгч ажиллахыг Ажлын хэсэг /Б.Ням-Очир/-т үүрэг болгосугай.

- Зарим газар нутагт заган ойн тооллого зохион байгуулах тухай 2024 оны А/261 дүгээр захирамжийн 1. Ойн тооллого, зохион байгуулалтын ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хяналт тавин, тайлан мэдээг хүлээн авч танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Д.Содномсамдан) үүрэг болгосугай.

- Баталгаажсан үүлдэр, омгийн малд шилэн сонголт ажлыг зохион байгуулах тухай 2024 оны А/199 дүгээр захирамжийн 1. Баталгаажсан үүлдэр, омгийн малд

үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн 2024 оны 11 дүгээр сарын 01-ний дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням)-т үүрэг болгосугай.

2.8.Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ:

Хэлтсүүдийн 2023 оны бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, нэгжийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хэлтэс тус бүрээс цахим сангаар ирүүлсэн тайлангаар тооцлоо. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй.

Хүснэгт 8.Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Хэлтсийн нэр	Хэрэгжилтийн хувь
1	2
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	77.14%
Хууль, эрх зүйн хэлтэс	70.00%
Нийгмийн бодлогын хэлтэс	70.00%
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	80.00%
Санхүү, төрийн сангийн хэлтэс	60.00%
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	-
Цэргийн штаб	66.67%
Залуучуудын хөгжлийн төв	23.33%

2.9.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ:

Засгийн газрын гишүүнтэй аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үүргийн биелэлт дунджаар 81.47 хувьтай байна.

Хүснэгт 9.Засгийн газрын гишүүнтэй аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үнэлгээний дүн

Хэлтсийн нэр	Гэрээний тоо	Гэрээний заалтын дундаж	Хавсралтын дундаж	Дундаж үнэлгээ
1	2	3	4	5
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	3	89.83%	-	89.83%
Хууль, эрх зүйн хэлтэс	4	92.50%	81.03%	86.77%
Санхүү, төрийн сангийн хэлтэс	3	69.70%	-	69.70%
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	14	80.29%	72.50%	76.4%
Нийгмийн бодлогын хэлтэс	6	79.91%	76.56%	78.24%
Цэргийн штаб	1	0	89.70%	89.70%

2.10.Хэлтсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ:

Хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын үнэлгээний багийн үнэлгээгээр тооцсон.

Хүснэгт 10.Хэлтсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний дүн

Хэлтсийн нэр	Дундаж хувь
1	2
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	95.24
Хууль, эрх зүйн хэлтэс	98.4
Санхүү, төрийн сангийн хэлтэс	100
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	93.7
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	97.69
Нийгмийн бодлогын хэлтэс	91.7
Цэргийн штаб	89.7
Залуучуудын хөгжлийн төв	87.8

2.11.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын агентлагуудын үнэлгээ:

Агентлагуудын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг 2023 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 18 агентлагийн үнэлгээ өссөн, 5 агентлагийн үнэлгээ буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16.Агентлагуудын 2023, 2024 оны эхний хагас жилийн үнэлгээний өөрчлөлт:

Д/д	Байгууллагын нэрс	2023 оны эхний хагас жилийн дүн	2024 оны эхний хагас жилийн дүн	Өсөлт/бууралт
1	2	3	4	5
1	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	-16.87	58	74.87
2	Орон нутгийн өмчийн газар	11.51	82	70.49
3	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	12.64	83	70.36
4	Худалдан авах ажиллагааны газар		65	-
5	Шүүх шинжилгээний хэлтэс	22.27	82	59.73
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	30.36	89	58.64
7	Цагдаагийн газар	30.64	73	42.36
8	Улсын бүртгэлийн хэлтэс	33.84	75	41.16
9	Нийгмийн даатгалын газар	36.62	74	37.38
10	Статистикийн хэлтэс	58.88	82	23.12
11	Татварын газар	70.03	90	19.97

1	2	3	4	5
12	Онцгой байдлын газар	66.2	85	18.8
13	Соёл, урлагийн газар	53.41	68	14.59
14	Санхүүгийн хяналт, аудитын алба	82.16	94	11.84
15	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	55.43	67	11.57
16	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	63.61	72	8.39
17	Хүнс, хөдөө аж ахуйн газар	64.63	73	8.37
18	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	73.88	82	8.12
19	Эрүүл мэндийн газар	60.91	67	6.09
20	Боловсрол, шинжлэх ухааны газар	60.38	60	-0.38
21	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	61.48	60	-1.48
22	Биеийн тамир, спортын газар	37.3	34	-3.3
23	Мал эмнэлгийн газар	70.76	64	-6.76
24	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	47.44	26	-21.44
Дундаж хэрэгжилт		47.3%	71%	24%

Гурав.Дүгнэлт:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны дүнг 2023 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулан үзэхэд дунджаар 10.2 хувь нэмэгдсэн байна.

Энэ нь зөвлөмжийн хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар авч эхэлсэн, аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системээр бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнаж хэвшсэнтэй холбон үзэж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 20.6 хувьтай байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 63.88 хувь болж 43.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 17. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн тайлангийн ирц

Хэлтсийн нэр	Нийт тайлангийн тоо	Тасалсан	Хоцорсон	Тайлангийн дундаж хэрэгжилт	Эцсийн үнэлгээ
1	2	3	4	5	6
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	9	0	0	83.3	83.3
Хууль, эрх зүйн хэлтэс	9	0	0	82.5	82.5
Нийгмийн бодлогын хэлтэс	10	0	4	74.7	66.7
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	5	0	2	77.8	73.8

Санхүү, төрийн сангийн хэлтэс	10	0	0	80.1	80.1
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	10	2	3	61.7	45.7
Цэргийн штаб	8		1	79.7	77.7
Залуучуудын хөгжлийн төв	5	2	1	37.7	25.7
Дүн	66	4	11	72.2	66.9


Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй, дэд хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол зэрэг 3 тайланг хугацаа хоцроон тайлагнасан.

Залуучуудын хөгжлийн төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө(сайдтай байгуулсан гэрээ)-ний хэрэгжилтийн тайлагнаагүй, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаа хэтрүүлэн тайлагнасан байна.

Нийгмийн бодлогын хэлтэс Дэд хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Зөвлөмжийн хэрэгжилт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс аймгийн Засаг даргын захирамж, зөвлөмжийн хэрэгжилт, Цэргийн штаб аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг тус тус хугацаа хоцроон тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нэгжийн үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгдсэн дүнг зураг 1-т үзүүлэв.



Зураг 1.Хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны дүн:



Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 54.5, Хууль эрх зүйн хэлтэс 14.4, Нийгмийн бодлогын хэлтэс 1.6, Санхүү, төрийн сангийн хэлтэс 6, Цэргийн штаб 52.2 хувиар тус тус өссөн бол Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 8.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс 7.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлалаар боловсруулж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн чиглэл, загвараар 2024 оны эхний хагас жилийн тайланг цаасан суурьтай хүлээн авсан. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа хүрсэн түвшин, зарцуулсан төсвийн тоон үзүүлэлтийг тайлбарын хамт ирүүлэх ёстой байсан хэдий ч тайланг загварын дагуу ирүүлээгүй, тоон үзүүлэлтийг тодорхой тавиагүй, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, үйл ажиллагаа, үр дүнг дутуу тайлагнасан зэрэг нийтлэг алдаа гарсан байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024 оны эхний хагас жилийн үнэлгээг 2023 оны эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулан үзэхэд дунджаар 24 хувиар өссөн нь харьяа хэлтсүүдийн хамтын ажиллагаа сайжирсантай холбоотой гэж үзэж байна.

ХЯНАСАН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 ХЭЛТСИЙН ДАРГА  Л.МАНДАЛ
 ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
 НИЙГМИЙН БОДЛОГЫН САЛБАРЫН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН  Б.БУЛГАМАА

